



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/132

Сангиндалай

Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12 дахь заалт, "Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль"-ийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Сангиндалай багийн нутаг дэвсгэрт Гэрчулуун, Замынгашуун нутагт мялзан өвчний сэжигтэй тохиолдол илэрч 2023 оны 06 дугаар сарын 06-аас 06-ны өдрөөс 06 дугаар сарын 20-ны өдрийг дуустал 14 хоногийн хугацаатай тогтоосон хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Малыг эрүүл мэндийн үзлэг, тандалтад бүрэн хамруулж ажиллахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нар, багийн Засаг дарга нарт малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн Тархвар зүйч Т.Машбат-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ард иргэд, малчдыг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг Онцгой комиссын орлогч дарга (Г.Энхдэлгэр), Хөдөө аж ахуйн тасагт үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/127 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ О.БАЗАРРАГЧАА



482302263